| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **17,529,060.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **17,529,060.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | **17,529,060.00** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:* Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын зорилго, үйл ажиллагааны чиглэлийг *"... Нийслэлийн гэр хорооллыг нийгэм, эдийн засаг, экологи, соёл боловсролын тогтвортой хөгжлийг хангасан суурьшлын бүс болгон хөгжүүлэх ..."* зэрэг үйл ажиллагаа явуулахаар тодорхойлжээ.

Тус газар нь 2022 онд стратегийн 4 зорилтыг хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

- Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу, дахин төлөвлөлтийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Нийслэлийн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулж, нийгмийн болон инженерийн дэд бүтцээр хангагдсан орон сууцны хорооллыг барьж байгуулах, инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хот, суурин газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд Нийслэлийн Засаг дарга, газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч болон төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдтэй гурван талт гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах;
- Байгуулсан гурван талт гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:* Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн албаны, Татварын багц хуулиуд, Нийгмийн даатгалын тухай хуулиуд болон ЗГ болон Сангийн Яамнаас гаргасан заавар, журам, НИТХ, Нийслэлийн Засаг даргын шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Нийслэлийн дотоод аудитын алба дотоод аудитыг хэрэгжүүлдэг ба тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс

үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

*Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,556,223.1 мянган төгрөгөөр буюу 29.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 30,553.3 | 20,151.8 | (10,401.5) |
| Урьдчилгаа | 12,000.0 | - | (12,000.0) |
| Бараа материал | 59,183.5 | 8,362,715.9 | 8,303,531.9 |
| Үндсэн хөрөнгө | 18,523,912.9 | 4,686,559.3 | (13,037,353.6) |
| **Нийт хөрөнгө** | **18,625,649.7** | **13,069,426.6** | **(5,556,223.1)** |
| Өр төлбөр | 5,559.4 | 601.7 | (4,957.7) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 18,620,090.3 | 13,068,624.9 | 77,591.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **18,625,649.7** | **13,069,426.6** | **(5,556,223.1)** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансууд байна.

Авлага дансны үлдэгдэл 20,151.8 мянган төгрөг болж 10,000.0 мянган төгрөгөөр буурсан нь Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "*... авлагыг төлүүлэх арга хэмжээ авч хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай*" 101/ШШ2022/04218 дугаар захирамж гарч, авлагын үлдэгдлээс 10,000.0 мянган төгрөгөөр барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,362,715.9 мянган төгрөг болж 8,303,531.9 мянган төгрөгөөр өссөн нь нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжээс чөлөөлүүлсэн газрыг аудитаар залруулга хийлгэж данс бүртгэлд бүртгүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа болон их хэмжээгээр худалдан авч нөөцлөөгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,686,559.3 мянган төгрөг болж 13,037,353.6 мянган төгрөгөөр буурсан нь 16,659,989.2 мянган төгрөгийн хөрөнгийг "Нийслэлийн Орон сууцны корпораци" ХК-д шилжүүлсэн, 43,212.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, 80,362.9 мянган төгрөгийн хөрөнгөд дахин үнэ тогтоож данснаас хассан зэргээс тус тус шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 601.7 мянган төгрөг болж 4,537.7 мянган төгрөгөөр буурсан нь 3,500.0 мянган төгрөгийн өглөгийг данснаас хассан, 1,000.0 мянган төгрөгийг төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд татварын 583.5 мянган төгрөгийн өглөг нийт өр төлбөрийн 96.9 хувийг эзэлж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 5,551,265.3 мянган төгрөгөөр буурсан нь зарим үндсэн хөрөнгийг бусад байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлж зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 687,000.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 687,000.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс 99,390.1 мянган төгрөгөөр төсвийг нэмэгдүүлж 786,390.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллыг зардлыг 91,137.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 36,093.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 53,799.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 24,563.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 49,449.3 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 7,628.0 мянган төгрөгөөр тус тус бууруулснаас шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 199,320.2 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Үүнд, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллыг зардлыг 171,294.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын

шимтгэлийн зардлыг 23,062.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 4,963.2 мянган төгрөгөөр тус тус бууруулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой болон төрийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлэх хууль, тогтоомжийн батлагдсан хугацаа хойшлогдсонтой холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр 587,070.6 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр нийслэлийн төсвөөс 583,665.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 532,829.0 мянган төгрөгийг зарцуулж, 61,622.0 мянган төгрөгийг нийслэлийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 532,829.0 мянган төгрөг буюу 90.8 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 31,680.8 мянга, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллыг 14,212.9 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,857.1 мянга, хангамж, бараа материалын зардлыг 3,074.3 мянга, нормативд зардлыг 2,018.5 мянга, бусад зардлыг 1,398.1 мянга, нийт 54,241.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71407 | 587,070.6 | 532,829.0 | (54,241.6) | 90.8 |
| | **Дүн** | **587,070.6** | **532,829.0** | **(54,241.6)** | **90.8** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/1118 дугаар захирамжаар Нийслэл хотын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд хэрэгжиж буй гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, түрээсийн болон орлогод нийцсэн орон сууц төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах, хянах шалгах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны зардалд 20,000.0 мянган төгрөгийг нийслэлийн ЗДТГ-аас санхүүжүүлжээ. Үүнээс захиалагчийн баннер сурталчилгааны *(ажлын хэсгийн уулзалт, тэдгээрийн зураг, дүрс бичлэгийг бэлтгэх)* зардлын гэрээний төлбөрт 6,400.0 мянга, судалгааны ажлын төлбөрт 3,500.0 мянга, тээврийн хөлсөнд 1,049.6 мянга, бичиг хэргийн зардалд 2,580.0 мянга, ажлын хөлс 4,000.0 мянга, нийт 17,529.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,470.9 мянган төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлан гаргалт, анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн хэлтсийн ахлах аудитор М.Ундармаа, аудитор Л.Энх-Амгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 1/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,155,976.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17,339.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь орлогчийн орон тоог, дуудлагын унаа хэрэглэснийг, албан хаагчдын ажлын хувцасны зардлыг, үүрэн холбооны утаснуудыг байгууллагын бүртгэлээс хасуулсан, сонин хэвлэлийн захиалгыг зогсоосон зэрэг арга хэмжээ авч төсвийг хэмнэж ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд дэд дарга, орлогчийн орон тоог хассанаар 11,975.2 мянган төгрөгийн цалинтай холбоотой зардал, албан тушаалын автомашинтай холбоотой 4,136.0 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардал, байгууллагын албан хаагчдад ажлын хувцас захиалгын зардал 2,018.5 мянган төгрөг, харилцаа, холбоо, хэвлэлийн зардал 772.3 мянган төгрөгийн хэмнэлтийг тус тус бий болгожээ.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Орон сууцны бодлогын газар нь 2022 онд нийт 28,795,612.2 мянган төгрөгийн 65 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 276,259.3 мянган төгрөгийн 18 мэдээллийг байршуулаагүй, 124,489.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 126,585.9 мянган төгрөгийн 1 мэдээллийг, зарлагын 64,092.9 мянган төгрөгийн 1 гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 85,580.5 мянган төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй, 124,489.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.*"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;"* заалтыг хэрэгжүүлээгүй байна.

  <u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### 4.4.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ болон бусад хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 477,556.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 3 зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 477,556.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 130.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 765.208.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагын биелэлт 100 хувьтай, 30,100.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгахаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 30,100.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн 10,000.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 130.0 | 1 | 130.0 | 100.0 |
| Албан шаардлага | 4 | 765,208.4 | 4 | 765,208.4 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | 30,100.0 | 1 | 10,000.0 | 66.6 |
| **Нийт дүн** | **7** | **795,438.4** | **7** | **795,438.4** | **88.9** |

Хан-Уул дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах бие даасан инженерийн шугам сүлжээ бүхий 40 айлын загвар “Сервис центр”-ийн удирдлагын төвийн техник, технологийн шийдэл, тохижилтын ажлын гүйцэтгэгчээр шалгаруулсан “Шинэ шар хад” ХХК-тай холбоотой 2017 онд үүссэн 30,100.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэх гаргажээ. Тус шүүхийн шүүгчийн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 101/ШШ2022/04218 захирамжид хариуцагчаар нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангуулж хохирлыг дээрх компаниар төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Захирамжийн дагуу 10,000.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, үлдсэн төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой иргэд, аж ахуйн нэгжээс газрыг чөлөөлүүлж бүртгэсэн 8,303,531.9 мянган төгрөгийн газрын гэрчилгээг баталгаажуулсан эсэхийг;

- Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 101/ШШ2022/04218 захирамжид хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангуулж хохирлыг "Шинэ шар хад" ХХК-иар төлүүлэхээр захирамжилсны дагуу төлбөрийн барагдуулалтад тус тус анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,413,694.9 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс, аудитын явцад 8,408,009.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,685.0 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Дахин төлөвлөлтийн үр дүнд чөлөөлөгдсөн жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүнг анхан шатны баримтын дүнтэй тулгахад 59,751.1 м2 бүхий 8,313,200.5 мянган төгрөгийн газрыг бүртгэж тайлагнаагүй;
- Санхүүжилтийн эх үүсвэрийг 58,207.0 мянган төгрөгөөр, урсгал зардлын дүнг 7,380.5 мянган төгрөгөөр тус тус дутуу, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийн 20,000.0 мянган төгрөгийг тус тус тайлагнаагүй;
- Ашиглаж байгаа санхүүгийн "Acolous 3.0" программ бүртгэл данснаас хассан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу бүртгэсэн;
- Засгийн газрын сан дансыг 3,901.9 мянган төгрөгөөр илүү, санхүүгийн үр дүнгийн үнэ төлбөргүй гарсан зардлыг 3,500.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;

Аудитаар нийт 1,567.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснийг арилгуулах 1,567.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

### 5.1. Албан шаардлага

Дуудлагын автомашин хэрэглэхдээ өдөрт 40 км-ээр ашигладаг боловч илүү цагаар ажиллуулж үр ашиггүй зардал гаргасан. Энэ нь Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны 204 дүгээр тогтоолын 8. *"энэ тогтоолын хавсралтад заасан суудлын автомашиныг өдрийн 60 км, дуудлага үйлчилгээний автомашиныг өдрийн 40 км-ээс хэтрүүлэхгүйгээр ашиглах байхаар тогтоосугай"* заалтыг зөрчиж байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. **Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудлын талаар:**

<u>*Илрүүлэлт:*</u> "Баян ач буян" ХХК-иар хэвлүүлсэн 4,460.0 мянган төгрөгийн санал хураалтын хуудас, урилга, танилцуулга, "Тод рүн" ХХК-иас авсан 1,225.0 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансаар дамжуулан бүртгээгүй зарцуулсан. Уг зөрчил нь бараа материалын журнал, дэлгэрэнгүй бүртгэл, тодруулга тайланг буруу илэрхийлэхэд үр дагавар бий болсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 *"Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна"* заалтыг зөрчсөн байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Худалдаж авсан бараа материалыг холбогдох дансаар дамжуулан бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засгийн газрын сан дансыг илүү илэрхийлсэн | 1 | 3,901.9 | | | 1 | 3,901.9 | 1 | 3,901.9 | | | | |
| Тайлант жилийн зардлыг дутуу илэрхийлсэн | 1 | 3,500.0 | | | 1 | 3,500.0 | 1 | 3,500.0 | | | | |
| Дахин төлөвлөлтийн үр дүнд 59.751.1 м2 бүхий 8.313.200.5 мянган төгрөгийн газрыг бүртгэж тайлагнаагүй | 1 | 8,313,200.5 | 1 | 8,313,200.5 | | | 1 | 8,313,200.5 | | | | |
| Төсвийн тайланд санхүүжилтийн эх үүсвэрийг, урсгал зардлыг дутуу, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийн эх үүсвэрийг тайлагнаагүй | 1 | 85,587.5 | | | 1 | 85,587.5 | 1 | 85,587.5 | | | | |
| Санхүүгийн "Acolous 3 0" программыг бүртгэл данснаас хассан. | 1 | 770.0 | 1 | 770.0 | | | 1 | 770.0 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу илэрхийлсэн. | 1 | 1,050.0 | 1 | 1,050.0 | | | 1 | 1,050.0 | | | | |
| Бараа материалын дансаар дамжуулан бүртгээгүй зарцуулсан. | 1 | 5,685.0 | 1 | 5,685.0 | | | | | | | 1 | 5,685.0 |
| **Дүн** | **7** | **8,413,694.9** | **4** | **8,320,705.5** | **3** | **92,989.4** | **6** | **8,408,009.9** | **-** | **-** | 1 | 5,685.0 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дуудлагын автомашин хэрэглэхдээ өдөрт 40 км-ээр ашигладаг боловч илүү цагаар ажиллуулж, үр ашиггүй зардал гаргасан. | 1 | 1,567.6 | | | 1 | 1,567.6 | | | | | | |
| **Дүн** | **1** | **1,567.6** | **-** | **-** | **1** | **1,567.6** | | | **-** | **-** | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэлгүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, зарлагын гүйлгээтэй холбоотой 1 мэдээлэл, мэдээлэлгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 14 мэдээллийг мэдээлэлгүй. | 1 | 400,748.4 | | | | | 1 | 400,748.4 |
| **Дүн** | **1** | **400,748.4** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **400,748.4** |